



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

**Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
бүрэлдэхүүн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын өмчлөлд байгаа төрийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллах чиг үүрэг бүхий өмч хамгаалах орон тооны бус, зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Захиргаа удирдлагын газрын дарга

Гишүүд:

Ерөнхий нягтлан бодогч

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгал, тохируулгын асуудал хариуцсан мэргэжилтэн

Шинэ эм, инновацийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Оношлуурын бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2022 01091

Эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт, өртөг үр
дүнгийн судалгааны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Хангалт, аж ахуйн менежер

2.Тушаалын хэрэгжилтийг хангуулж, байгууллагын өмч хамгаалах үйл ажиллагаатай холбоотой ажлын төлөвлөгөөг батлуулж, тайланг хагас бүтэн жилээр гарган “Даргын зөвлөл”-ийн хуралд тайлагнаж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдхүүн батлах тухай” Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/133 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д. НАРАНТУЯА